



Аймгийн Засаг даргын 2008 оны  
342 дугаар захирамжийн хавсралт

“МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ” ХХК-ИЙН БУЛГАН АЙМГИЙН САЛБАРЫН  
БУЛГАН ХОТЫН ДОТОРХИ 8324 МЕТР ГАЗРЫН  
ГОЛ КАБЕЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАРХАЛТ

1. Гурил тэжээл Булган ХК-иас, Зүүн түрүү чиглэлийн 1894 метр газрын сүлжээний тархалт:

- Холбооны кабелийн Шахтаас баруун чигт эргээд М 1, М 2 худгаар дамжин Шинэ зуун худалдааны төвийн зүүн талаар урагшаа эргэн М 3, М 4, М 5, М 6 худгаар хуучин холбооны цагаан байрны урд талын явган хүний замын хажуугаар зүүн тийш эргэж М18, М17, М16 ,М15 худгаар тус тус дамжин ЭБЦТС ТӨХК-ийн Булган дахь салбарын конторын дэргэд байрлах ХШ-1 хувиарлах шүүгээ хүртэл

461 метр сувагчлал

- ЭБЦТС ТӨХК-ийн Булган дахь салбарын конторын урд талын М15 худагнаас Гурил тэжээл Булган ХК-ийн -ийн урд талд байрлах ХШ-8 хувиарлах шүүгээ хүртэл М 14,

M13, M12, M11, M10, M9, M8 худгуудаар дамжих

580 метр сувагчлал

- Гурил тэжээл Булган ХК-ийн урд талын М 8 худагнаас М 7 худагаар дамжин 2 а хорооны 12 дугаар гудамжинд байрлах ХШ-12 хувиарлах шүүгээ хүртэл

441 метр сувагчлал болон гол кабель

- Холбооны кабелийн Шахтаас М1 худгаар гарч зүүн тийш 10, 11-р байрны чиглэлд М100, М 99, М 98, М 97-р худгуудаар дамжин, Бага сургуулийн хашааны хаалга хүртэл

412 метр сувагчлал

2. “ Булган Мээж ” ХХК-иас, 3-ын В,Г, 16, 17-р байрны чиглэлийн 2532 метр газрын сүлжээний тархалт:

- Холбооны кабелийн Шахтаас М1 худгаар гарч Шинэ зуун худалдааны төвийн зүүн өнцөгт байгаа М 2 худгаар дамжин хойш эргэн авто зам хөндлөн гарч “Булган Мээж” ХХК-ны зүүн урд талын саадны өнцөгт байрлах М 58 худгаар баруун тийш эргэн Өрнөх кафе хажууд ХШ-7 хувиарлах шүүгээ хүртэл М 59, М 60 худгаар дамжих

316 метр сувагчлал

- “Булган Мээж ” ХХК-ны урд талын М 58 худагнаас зүүн тийш эргэн М 91 худагаар хойд зүгт эргэн Номын титэм дэлгүүрийн зүүн талаар, авто замын баруун талаар

М 90 худгаар дамжин 3-ын В, Г хорооны эхний гудамжуудын дунд байрлах ХШ-13 хүртэл

329 метр сувагчлал

- ХШ-13 хувиарлах шүүгээний урд талын М 90 худагнаас авто замын хойд талаар, 3-р В, Б хорооны урдуур “Эмийн цэцэглэн” өрхийн эмнэлэг, 3-ын А хорооны урдуур баруун тийш чиглэлд М 87, М 86, М 84, М 83, М 82, М 81, М 80 худгуудаар дамжин 17-р байрны зүүн хойд өнцөгт байрлах ХШ-14 хувиарлах шүүгээ хүртэл

737 метр сувагчлал

- ХШ-13-аас 3-ын В-ын арын анкер хүртэл газар доогуур 1150 метр

### 3. ХШ-10 чиглэлийн 1299 метр газрын сүлжээний тархал

- “Булган Мээж” ХХК-ны урдах М58 худагнаас баруун дээш чиглэлд эргэн Жаргалант дэлгүүр, Чин туул барааны зах, Гэгээ дэлгүүр, Хэвлэх үйлвэрийн байр, ХАА-н хоршоологчдын холбоо, Аймгийн ЗДТГ, 1, 6-р цэцэрлэг зэрэг газруудын урд талаар М 59, М 60, М 61, М 62, М 63, М 64, М 65, М 67, М 67, М 68, М 74 худгуудаар дамжин 14-р байрны урд өнцөгт байрлах ХШ-6 хувиарлах шүүгээ хүртэл

841 метр сувагчлал

- 14- байрны урд талын М 68 худагнаас дээш эргэн авто замын хойд талаар М 69, М 70, М 71, М 72, М 73 худгуудаар дамжин 6-ын А хорооны чигтээ байгаа НИК ШТС-ын замын эсрэг талд байрлах ХШ-10 хувиарлах шүүгээ хүртэл

458 метр сувагчлал

4. Булган сумын Засаг даргын тамгийн газрын чиглэлийн 2899 метр газрын сүлжээний тархалт:

- Шинэ зуун худалдааны төвийн зүүн өнцөгт байрлах М 2 худгаар урагш эргэн М 3, М 4, М 5, худгаар дамжин хуучин холбооны цагаан байрны урд талын М 6 худгаар дээш эргэн Номын сан, Хүүхдийн төлөө төвийн урдуур М 18, М 19, М 20 худгуудаар Хөгжимт жүжгийн театрийн урд байрлах ХШ-4 хувиарлах шүүгээ хүртэл

378 метр сувагчлал

- Хөгжимт жүжгийн театрын урд далын М 20 худагнаас дээш өгсөөд Баясуулагч захын урдуур гараад М 21, М 22, М 23 М 24 худгаар дамжин Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны дэргэдэх ХШ -5 хувиарлах шүүгээ хүртэл

324 м етр сувагчлал

- Нийтийн номын сангийн өмнөх М19 худагнаас садаар урагшаа М 43, М 44, М 45, М 46 худгаар нэвт гарч М 47 худгаар Булган хотын урд нүүрээр зүүн тийш эргэн М 48, М 50 худгаар дамжин Булган сумын Засаг даргын тамгийн газрын дэргэдэх ХШ-2 хувиарлах шүүгээ хүртэл

416 метр сувагчлал

- Есүсийн байрны арын явган хүний замын хажууд байрлах М 45 худагнаас баруун дээш эргэн МАХН-ын байр, 8 дугаар байрны арын явган хүний замын хажуугаар өгсөх М 42, М 41, М 40 худгаар дамжин Булган зочид буудлын зүүн хойд өнцөгт байрлах ХШ-3 хувиарлах шүүгээ хүртэл

228 метр сувагчлал

- Хөгжимт жүжгийн театрын баруун талын М 21 худагнаас хойд чиглэлд өнөр барааны дэлгүүрийн баруун талаар авто зам хөндлөн гарч М 62 худаг хүртэл

265 метр сувагчлал

- Газрын албаны зүүн өнцөгт байрлах М 26 худгаас хойд чиглэл рүү зам хөндлөн гарч 1-р цэцэрлэгийн урд талын М 66 худаг хүртэл

265 метр сувагчлал

- Булган зочид буудлын М 40 худагнаас дээд чиглэлд авто зам хөндлөн гарч Эрүүл мэндийн газрын араар Халдвартын больницийн ар М 33 худаг хүртэл

506 метр сувагчлал

- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны М 25 худагнаас Нэгдсэн эмнэлгийн чиглэл дэхь М 26, М 27, М 28, М 29, М 30, М 31, М 32 худгуудаар дамжин Нэгдсэн эмнэлэг хүртэл

517 метр сувагчлал